“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2021 ОНЫ 08 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны 08 дугаар сарын 31 — Багануур дүүрэг

| № | ҮНДЭСЛЭЛ | ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ |
|---|---|---|---|
| 1. | БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл | - Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, МУЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1.11.3, НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.2 дахь заалтын хүрээнд паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгааны хэсгийг баталгаажуулах явцад хяналт тавьж байна.<br>- Паркийн цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн 7,3км урт агаарын шугам болон үндсэн дэд станц болох 110/35кВ-ын зураг төсөл, паркийн үндсэн 110/35кВ-ын дэд станцаас Хүнд үйлдвэрлэлийн бүсэд байгуулагдах цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 35кВ-ын агаарын шугам болон 35/10кВ-ын төмөрлөг дэд станцын зураг төсөл, төсөв ЭХЯ-ны Эрчим хүчний хөгжлийн төвийн магадлалаар хянагдан 209/2021 дугаартай нэгдсэн дүгнэлт гарч баталгаажин бүрэн дууссан.<br>- Зураг төсөл гүйцэтгэгч Мон-Энержи Консалт ХХК нь үндсэн захиалагч болох БХБЯ-нд зураг төслийг хүлээлгэж өгөхөөр бэлтгэж байна.<br>Мөн Эрчим хүчний яамнаас паркад олгосон 110 кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугам барих техникийн нөхцөлийн хугацаа дууссан тул уг асуудлаар тус яаманд хандаж техникийн нөхцөлийн хугацааг дахин сунгуулан паркийн үндсэн цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. | 98% |
| 2. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.2 | НЗД-ын А/483 дугаар захирамжийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:<br>- Ажлын хэсгийн гишүүд 2 удаагийн цахим уулзалт, 1 удаагийн танхимын уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж бүх үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааны чиглэлийн талаарх танилцуулгыг төрийн захиргааны төв байгууллагад танилцуулсан.<br>- БҮТП ОНӨТҮГ-ын дарга, холбогдох мэргэжилтнүүдийн хамт НШУҮИГ-т томилолтоор ажиллаж, Паркийн статус, хөрөнгө оруулалтын талаар санал бэлтгэн НШУҮИГ-ын даргад танилцуулж ажилласан.<br>- Үйлдвэрлэл технологийн паркуудын үйл ажиллагааг шинэчлэн тодорхойлох, эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх ажлын хүрээнд холбогдох саналуудыг боловсруулж Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 120 дугаартай албан бичгээр НШУҮИГ-т хүргүүлсэн. | 100% |
| 3. | Байгууллагын 2021 оны үйл | - Хотын соёл аяны хүрээнд 08 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүл амьдралын зөв дадал хэвшил” сургалтыг нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан. Сургалтаар биологийн идэвхт цаг, зөв хооллохын ач тус, | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | ажиллагааны төлөвлөгөөний 1.2.4 | эрүүл амьдралын гол үндэс - дасгал хөдөлгөөний тухай, идэвхтэй амьдралыг бий болгох гол хүчин зүйлс зэрэг дэд сэдвийг хэлэлцэн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.<br>- 08 дугаар сарын 13-ны өдөр Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн компьютер техник хэрэгслийг бага ачааллуулах талаар сургалт зохион байгуулсан. | |
| 4. | Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж | - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- 2021 оны 08 дугаар сарын 01-нээс 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хариутай 2, хариугүй 5 нийт 7 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 80%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2.57<br>- 2021 оны 08 дугаар сарын байдлаар "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 10 хариугүй бичиг явуулсан. Шийдвэрлэлт-100%<br>- 8 дугаар сард ээлжийн амралт авсан 1 албан хаагчийн мэдээллийг ERP системд оруулж амралтыг бүртгэлжүүлсэн. | 90% |
| 5. | ЗГ-ын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол | - 2021 оны 08 дугаар сарын байдлаар байгууллагын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 9, цар тахалтай холбоотой 27 мэдээллийг байршуулсан. | 100% |
| 6. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль | - www.shilendans.mn сайтанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна.<br>- Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн 07 дугаар сарын мэдээг гарган 08 дугаар сарын 01-ний өдөр НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төлбөр, тооцоо хариуцсан мэргэжилтний ERP хаягаар хүргүүлсэн.<br>- Байгууллагын батлагдсан төсвийн дагуу сар, улирлын хуваарийг гаргаж зориулалтын дагуу зохистой зарцуулж байна. Сар бүрийн мэдээ, НД тайлан, татварын улирлын тайлан, санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж байна. | 100% |
| 7. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1.1 | - Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна.<br>- "Ковид 19 эрсдэл систем"-ийг бүх албан хаагчдад гар утсандаа суулган ашиглаж байна.<br>- Бүх албан хаагчид коронавирусын эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан.<br>- 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн байгууллагад коронавирусын халдвар бүртгэгдсэн эсэх судалгааг загвар хүснэгтийн дагуу гаргаж, 7 хоног бүрийн 1,3,5 дахь өдрүүдэд мэдээг шинэчлэн НЗДТГ-ын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний ERP чатад хүргүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | - Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 115, 118 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/477 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| НЭМЭЛТ АЖИЛ | | | |
| 8. | НУАШХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг НЗДТГ-ын О.Мандах мэргэжилтэн рүү хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. | | 100% |
| 9. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагт НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж байна. | | 100% |
| 10. | Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.2, Багануур дүүргийн Засаг даргын 2021 оны А/161 дүгээр захирамжийн 4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан "Хотын соёл" аяныг зохион байгуулах удирдамжийн дагуу тусгай төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган тайланг дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэст сар бүрийн 20-нд, НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Соён гэгээрүүлэх тасагт сар бүрийн 25-нд тус тус хүргүүлэн ажиллаж байна. | | 100% |
| 11. | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан "Шарилжгүй Улаанбаатар-6" аяныг дүүргийн хэмжээнд 2021 оны 08 дугаар сарын 05-07-ны өдрийн хооронд зохион байгуулах болсны дагуу хуваарьт талбайн шарилж устгалын ажлыг 08 дугаар сарын 05-ны өдөр гүйцэтгэж, тайланг мөн өдрийн 115 дугаартай албан бичгээр дүүргийн ЗАА-нд, dolgor.mashbat@gmail.com хаягт тус тус хүргүүлэв. | | 100% |
| 12. | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 01/192 тоот чиглэлийн дагуу байгууллагын салбар зөвлөлийн хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 117 дугаартай албан бичгээр дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэст хүргүүлэв. | | 100% |
| 13. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг, чадавхын судалгаа хийж байгаатай холбогдуулан байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэхэд мөрдлөг болгон ашигладаг хүчин төгөлдөр мөрдөж буй дүрэм, журам, стандарттай холбоотой мэдээллийг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 123 дугаартай албан бичгээр НЗДТГ-т, local.governance.ub@gmail.com цахим хаягт тус тус хүргүүлсэн. | | 100% |
| 14. | Улаанбаатар хотын Ерөнхий менежрийн 2021 оны А/01 дүгээр тушаалаар баталсан хуваарийн дагуу хичээлийн шинэ жилийг угтсан их цэвэрлэгээг хуваарьт талбайд зохион байгуулж тайланг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 125 дугаартай албан бичгээр дүүргийн ЗАА-нд хүргүүлсэн. | | 100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч. ЭЛБЭГСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГазар УГД0014 8184062 2715 109064

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЭНХЗАЯА